

## БНМАУ: ФЕОДАЛИЗМААС СОЦИАЛИЗМД ШИЛЖИХ ШИЛЖИЛТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД

С. К. Роцин

Капитализм, капитализмын өмнөх харилцаанаас социализмд шилжих шилжилтийн үе нь нийгэм-эдийн засгийн мөн чанар; стратеги зорилго, зорилтоороо нэгдмэл гэдгийг түүхэн туршлага гэрчилж байна. Шилжилтийн мөн чанар нь мөлжигч нийгмийг шинэ социалист нийгмээр хувьсгалт ёсоор халах, зорилго нь социализмын үндэс байгуулах явдал юм. Гэвч шилжилтийн үе шат бүр тодорхой агуулга, хэлбэр, өөрчлөн байгуулах арга, дэс дараагаараа ихээхэн ялгаатай. Учир нь хэлбэршлийн үндэс (капитализм буюу феодализм) адилгүй, үйлдвэрлэх хүчний уг байгаа түвшин эрс ялгаатай билээ.

В. И. Ленин тэмдэглэхдээ, буурай хөгжилтэй орон капиталист биш хөгжлийн үед нэлээд аажим, нэлээд хянуур, шат дараатайгаар социализмд шилжинэ гэжээ.<sup>1</sup> «Социализмд шууд шилжин орох манай зорилтыг... амжилттай шийдвэрлэж чадахын тулд капитализмын өмнөх харилцаанаас социализмд шилжин ороход нь зуучлах ямар зам, ямар арга барил, ямар хэрэгсэл, ямар дэмжлэг хэрэгтэй байгааг ойлгох хэрэгтэй»<sup>2</sup> гэж В. И. Ленин бичсэн байдаг.

БНМАУ-ын шилжилтийн үе нь юуны өмнө, капитализмаас социализмд шилжих үед байдаггүй нэлээд хэдэн нэмэлт онцлог, тухайлбал, феодалын харилцаа, феодализм, колоницлолын бүхий л үлдэгдлийг устгах, капиталист орнуудад нэгэнт байдаг материал, нийгэм, соёлын урьдчилсан нөхцөлийг бий болгох зорилтыг шийдвэрлэснээр тодорхойлогдоно. Үүнтэй уялдаж шилжилтийн үеийн олон шат (нийт ардчилсан, социалист шат) хөгжлийн завсрын, нэмэлт үе зайлшгүй хэрэгтэй болсон бөгөөд шилжилтийн үед шийдвэрлэх эдийн засгийн зорилт өвөрмөц онцлогтой байсан юм.

БНМАУ-ын шилжилтийн үеийн нэн чухал асуудал бол түүний аль ч үе шатанд үйлдвэрлэх хүчний өсөлт байлаа. Үйлдвэрлэх хүчний өндөр түвшингүйгээр, машинт том үйлдвэрлэлийг бүх салбарт нэвтрүүлэхгүйгээр социализм сэтгэшгүй болохоор энэ бол үндсэн гол зорилт байлаа. Чухамхүү хангалттай өндөр түвшинтэй үйлдвэрлэх хүчин нь социалист үйлдвэрлэлийн харилцааны бэхжилт, нийгмийн эдийн засгийн бүхий л бүтцийг социалист ёсоор өөрчлөн байгуулахтай хамгийн шууд холбоотой юм. Үйлдвэрлэх хүчин хөгжихийн зэрэгцээ нийгмийн бүтэц эрс өөрчлөгдөн, орчин үеийн нийгмийн тэргүүний хүч ажилчин анги бүрэлдэн бий болж, өсөн бэхжиж сэхээтний үүрэг нэмэгдэж байна,

Хувьсгалт Монгол хуучин нийгмээс туйлын хоцрогдсон үйлдвэрлэх хүчнийг өвлөн авсан билээ. Материаллаг үйлдвэрлэлийн цорын ганц салбар гэвэл бүхэлдээ гар хөдөлмөрт тулгуурласан, бараглан байгалийн бүрэн эрхшээлд байсан нүүдлийн эрчимгүй мал аж ахуй байлаа. Цорын ганц үйлдвэрлэгч анги нь бараг толгой дараалан би-

чиг үсэг үл мэдэх хамжлагын ардууд байв. Таваар-мөнгөний харилцааны хөгжил сул, эдлэхүүний, хагас эдлэхүүний аж ахуй ноёрхож байлаа.

1921 оны хувьсгал үйлдвэрлэх хүчний хөгжлийг саатуулан барьж, түүнийг зогсонги, дорой байдалд хүргэсэн феодализм, колоничлолыг халан устгалаа. Энэ нь үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх хүчирхэг хүчин зүйл болсон юм. Ардын ардчилсан байгуулал эдийн засгийн гол үндэс болсон хөдөө аж ахуйг хөгжүүлэх, шинэ шинэ салбарыг бий болгох машин техникийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх улс төрийн зайлшгүй нөхцөлийг хангажээ.

Үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх гол зам, хэрэгслийн нэг бол, ялангуяа, нийт ардчилсан шатанд жижиг таваарын үйлдвэрлэл, ардын хувийн аж ахуйтны өсөлт байлаа. Феодалын хараат байдал, мөнгө хүүллийн боолчлолоос ангижирсан ардууд жижиг таваар үйлдвэрлэгч анги болов. Улсаас ардуудын хувийн аж ахуйн идэвхи санаачилгыг дэвжээхэд бүх талын тус дөхөм үзүүлж, тэдэнд зээллэг олгож, олон талын тусламж үзүүлж, таваар-мөнгөний харилцааны хөгжилд түлхэц өгчээ. Ардын аж ахуйн эдлэхүүний байдлыг даван туулах, түүний таваарлаг чанарыг дээшлүүлэх, хэрэгцээг сайжруулахад хоршооллын ба улсын худалдааны байгууллага чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Зарц-ядуучуудын давхарга улсаас ихээхэн дэмжлэг авч, хөдөө орон нутагт ардуудын дундчууд болох үйл явц идэвхтэй явагдсан байна. Энэ бүхэн үр дүнгээ өгч, тус орны малын тоо толгой 1940 онд 1924 оныхоос 1,9 дахин өсч, бүтээгдэхүүний таваарын гаргалт мэдэгдэхүйц өсчээ. Гэвч цаашид нөхөн үйлдвэрлэлийг байнга өргөтгөх, хөдөлмөрийн эрчимтэй аргыг өргөн нэвтрүүлэхэд ардын жижиг аж ахуйн боломж, түүний чадваргүй байдлын хязгаарлагдмал тал улам бүр илэрсэн юм. Үүний зэрэгцээ, ардын үйлдвэрлэлийг идэвхтэй хөгжүүлэн бэхжүүлэх, түүний нөөцийг нэн сайн ашиглах нь шилжилтийн үед үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх анхдагч зүйл мөн бөгөөд дотоод хуримтлал бүхэлдээ эдийн засгийн өсөлтөнд асар их ач холбогдолтой нь эргэлзээгүй.

Үйлдвэрлэх хүчний хөгжил, таваар-мөнгөний харилцааг хангахад хөдөө аж ахуй, мөн худалдаа, гар үйлдвэрийн хүрээн дэх мөлжигч этгээдүүдийн талаар явуулсан бодлого тодорхой үүрэг гүйцэтгэжээ. Тэдгээрийн үйл ажиллагааг (тодорхой хүрээнд) хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд тэд хөдөө аж ахуй, гар үйлдвэрийн өсөлтөнд тус дөхөм болсон юм. Тэр үед хувийн капиталист хэвшил бүрэлдэн бий болохыг саатуулсан татварын бодлого бусад арга хэмжээ авах замаар үндэсний капиталист элементийг хязгаарлах чиг шугам явуулсан нь тус орны капиталист биш хөгжлийн чухал зүйл байв.

Улс, хоршооллын үйлдвэр, байгууллагыг байгуулсан нь үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх шийдвэрлэх зам болсныг тэмдэглэх хэрэгтэй аж үйлдвэр, механикжсан тээвэр, холбоо, үндэсний худалдаа, санхүүгийн систем зэрэг эдийн засгийн салбарууд улс, хоршооллын гар төвлөрөв. Хөдөө аж ахуйд сангийн аж ахуй, ардын үйлдвэрлэлийн нэгдлийн тоо аажмаар өсчээ. Социалист үйлдвэрийн газруудад монголын нийгмийн тэргүүлэх хүч болсон ажилчин анги бүрэлдэн тогтож өсөн бэхжив. Ажилчин албан хаагчдын тоо 1940 онд 33,1 мянга байсан бол 1960 онд 144,6 мянга, түүний дотор ажилчдын тоо 14,8 мянгаас 66,2 мянга болон өсчээ.<sup>3</sup>

Социалист секторт үйлдвэрлэх хүчин тогтвортой, түргэн хурдацтай хөгжиж, машины үйлдвэрлэл өргөн нэвтэрчээ. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 1940-1960 онд 5,4 дахин, түүний дотор үйлдвэрийн хэрэгслийн үйлдвэр 5,8 дахин, хэрэглээний зүйл 5, 1 дахин өссөн байна. Бүх төрлийн тээврийн ачаа эргэлт 244,2 дахин өсчээ.<sup>4</sup> Үндэсний орлогын үйлдвэрлэлийн бүтцэд аж үйлдвэр, барилга, тээвэр, холбооны эзлэх хувийн жин 1940 онд 9,9% байсан бол 1960 онд 30,4%-д хүрч, түүний дотор аж үйлдвэрийнх 8,5%-14,6%-д хүрч хөдөө аж ахуйн эзлэх хувь 61,0-22,9% болон буурсан байна.<sup>5</sup> Улс ардын аж ахуйн үндсэн фондын салбарын бүтцэд нэлээд өөрчлөлт гарчээ. Үйлдвэрлэлийн үндсэн фондод аж үйлдвэр, барилга, тээвэр, холбооны эзлэх хувийн жин 1940-1960 онд 7%, -43,1 % өсч, хөдөө аж ахуйнх 80,0-28.9% болон буурсан байна.<sup>6</sup>

БНМАУ шилжилтийн үеийн сүүлээр дан ганц мал аж ахуйн орноос хөдөө аж ахуй аж үйлдвэрийн орон болов. Ганц салбартай эдийн засаг олон салбартай болж, гол байраа хадгалсаар буй уламжлалт мал аж ахуйн зэрэгцээ хөнгөн, хүнд үйлдвэрийн хэд хэдэн салбар, барилга, тээвэр, холбооны орчин үеийн төрлүүд, газар тариалантай болов. Энэ бол үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх, эдийн засгийн потенциалыг нэмэгдүүлэхэд томоохон түлхэц болсон юм. Ингэхдээ үндэсний орлого, үндэсний нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь ердийн нэг нэмэгдсэн хэрэг биш, үйлдвэрлэх хүчний бүтцэд ч чанарын өөрчлөлт гарсныг харгалзах хэрэгтэй. Чанарын эдгээр өөрчлөлт нь нэгдүгээрт, хөдөлмөрийн механикжсан хэрэгслийн хувийн жин үлэмж өссөн, хоёрдугаарт ажилчин анги, ардын сэхээтний роль дээшилсэн, гуравдугаарт хөдөлмөрчдийн бүх давхаргын соёл, мэргэжлийн түвшин өссөнөөр тодорхойлогдоно. Тус оронд социализмын материал техникийн баазын үндэс суурь тавигдсан нь зарчмын чухал ач холбогдолтой байлаа.

Шилжилтийн үеийн эдийн засгийн чухал асуудлын нэг бол тус орон эдийн засгийн биеэ даасан байдалтай болсон явдал юм. Хувьсгалын эхний жилүүдэд Монголын дотоод, гадаад зах зээл дээр гадаадын худалдаа-мөнгө хүүллийн пүүсүүд ноёрхож байв. Энэ нь тус орны эдийн засаг бүхэлдээ гадаадын капиталын боолчлогын хараат байсныг харуулж байна. Үндэсний эдийн засгийн өсөлтийг хангахын тулд, үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх, тус орны баялгийг хилийн чанадаас сорон мөлжиж, тэгш бус худалдаа хийж байсан гадаадын худалдаачдын түрэмгий нөлөөнөөс зайлшгүй ангижрах хэрэгтэй байв. Гадаадын пүүсэнд төлөх өрийг хүчингүй болгож, тэдэнд ихээхэн хэмжээний гааль, татвар оногдуулж, ардын төв хоршоо байгуулан, Улсын банк нээж, үндэсний мөнгөн тэмдэгт гаргасан явдал энэ чиглэлд чухал арга хэмжээ болжээ. 20-иод онд Монголын зах зээл дээр, нэг талаас улсаас бүх талын дэмжлэг, Зөвлөлтийн худалдааны байгууллагын тусламж авч байсан шинээр бий болсон үндэсний худалдааны байгууллага, нөгөө талаас гадаадын олон тооны худалдааны пүүсийн хооронд хурц ширүүн тэмцэл явагдаж байлаа. Энэ тэмцэл гадаадын пүүсүүдийг бүрэн шахан зайлуулснаар дууссан билээ. 1930 онд гадаад худалдаанд онц эрх тогтоосон нь тэдэнд эцсийн цохилт болсон юм. Гүйлгээний хүрээнд монголын хоршооллын болон улсын худалдааны байгууллагууд дийлэнхи нь болов. 50-иад оны эцэс хүртэл үн-

дэсний хувийн худалдаачид байсаар байсан бөгөөд жижиглэн худалдаалалтанд тэдний эзлэх хувийн жин 1940 онд 10,1 % байсан бол 1950 онд 11,6 хувь, 1955 онд 3,3% болжээ.<sup>7</sup>

БНМАУ-ын эдийн засгийн бодлогод үйлдвэрлэлийн харилцааны системийг хувьсгалчаар өөрчлөн байгуулсан явдал гол байр эзэлдэг. Энэ нь капитализмын өмнөх харилцаанаас шилжилтийн үед орсон нөхцөлд онцгой хүнд бэрх, олон талт зорилт болдог. Шилжилтийн үеийн эдийн засгийг тодорхойлж В. И. Ленин тэмдэглэхдээ: «Тухайн байгуулалд капитализм, социализм хоёрын аль алиных нь элемент, хэсэг, өөдөс байна гэсэн үг»<sup>8</sup> гэжээ. Энэ бол капитализмаас социализмд шилжих үеийнх юм. Феодализмаас социализмд шилжих үед үүн дээр юуны өмнө, гол төлөв феодализмын элемент нэмэгдэнэ. Ийнхүү хамгийн нэн тэргүүний амин чухал зорилтын нэг нь феодалын харилцааг устгахын төлөө тэмцэл байв. Энэ бол хэд хэдэн үе шат бүхий урт удаан хугацааны үйл явц байлаа. 1921—1924 онд төв, орон нутагт алба гувчуур, хамжлагат ёсыг халж, газрыг улсын болгожээ. Энэ бүхэн Монголын феодализмын үндсийг ноцтой ганхуулсан юм. Гэвч мал аж ахуй дахь үйлдвэрлэлийн чухал хэрэгсэл, гол баялаг болох мал сүргийн ихэнх хэсэг феодалуудын хувийн өмч хэвээр үлдсэнээр тэд эдийн засгийн хувьд нэлээд хүчтэй байр суурь эзэлж байв. Дөнгөж 1929—1931 онд хар феодалуудын, 30-аад оны эцсээр сүм хийдийн хөрөнгийг хурааснаар феодализм мөхөж, феодал анги оршин тогтнохоо больжээ.

Эдлэхүүний, хагас эдлэхүүний ардын аж ахуйг жижиг таваарын аж ахуй болгон хувиргах үйл явц урт удаан хүнд бэрх байв. Эдлэ хүүний байдлыг даван туулах нь феодалын харилцаа, түүний үлдэгдлийг устгах, мөн мөнгө хүүлэгчдийг шахан зайлуулахтай нэгэн зэрэг явагдсан юм. Хувийн аж ахуйтны санаачилгыг хөхүүлэн дэмжиж, үндэсний худалдаа, эд хэрэглэгчдийн хоршооны үйл ажиллагааг өрнүүлэн, хот хөдөөгийн болон улс, хоршооллын үйлдвэр, байгууллага, орон нутгийн аж ахуйн холбоог өргөтгөсөн зэрэг нь ардын аж ахуйн таваарлаг чанарыг нэмэгдүүлж, хотод ч хөдөөд ч таваар-мөнгөний харилцааг хөгжүүлжээ. 40-өөд оны эхээр жижиг таваарын хэвшил эдийн засагт зонхилох болов.

БНМАУ-д социалист хэвшил бүрэлдэн бий болсон нь өвөрмөц, онцгой нарийн төвөгтэй байснаараа ялгагдана. Зарим онцлогийг нь авч үзье. Нэгдүгээрт, социалист хэвшил нь ардын ардчилсан байгууллын үед ардчилсан ба социалист зорилт харилцан уялдаатай, харилцан нөхцөлдөж тус орны капиталист биш хөгжлийн чиг шугамыг тууштай явуулсны ачаар боломжтой болсон бүр шилжилтийн үеийн нийт ардчилсан шатанд үүсчээ. Хоёрдугаарт, социалист өмч нь капиталист өмчийг нийгэмчлэх үндсэн дээр биш, материаллаг үйлдвэрлэлийн салбар байхгүй шахам үед үүссэн юм. Феодалын өмчийг хураасны үрээр л сая зарим хэсэг нийгмийн өмч бий болжээ. Социалист хэвшил үндсэндээ, улсын буюу үйлдвэрлэлийн хоршоолол, аж ахуйн байгууллагын хөрөнгө эдийн засгийн бүх салбарт шинээр бий болсны үрээр бүрэлдэн тогтсон юм. Гуравдугаарт, хоршооллын онцгой үүрэг роль гэвэл социализмд тариачдыг оролцуулах хамгийн энгийн дөт зам болдогт оршино гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. БНМАУ-д эд хэрэглэгчдийн, үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн, өөрөөр хэлбэл, гүйл-

гээний хүрээнд ч энгийн болон нэлээд төвөгтэй хоршооллын янз бүрийн хэлбэр газар сайгүй өргөн дэлгэрч байв.

БНМАУ-ын эдийн засагт урт удаан хугацаанд (20 гаруй жил) жижиг таваарын, мөн социалист гэсэн хоёр хэвшил байлаа. Нийт ардчилсан зорилтыг тийн шийдвэрлэсэн нь бүрэн зүй ёсных байв. Гэвч социализмын үндэс байгуулах явдал гол зорилт болоход жижиг таваарын үйлдвэрлэлийг социалист ёсоор өөрчлөх асуудал гарч иржээ. Энэ нь улс төр, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсээр тулгаран гарсан юм. Хөдөө аж ахуйг социалист ёсоор шинэчлэх ажил 50-иад оны эцсээр дууссан ардын үйлдвэрлэлийн хоршооллын үндсэн дээр хэрэгжсэн байна. Энэ нь хоршооллын ерөнхий зарчмын дагуу явагдсан боловч нүүдлийн мал аж ахуйг нэгтгэсэн, мөн харьцангуй сул дорой техникийн бааз дээр өргөн аж үйлдвэржүүлэлт явуулсан маш өвөрмөц онцлогтой юм. Эндээс нийгмийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, зохион байгуулахад нэмэлт бэрхшээл, онцлог гарч байна. Түүнчлэн хөдөө аж ахуйд үйлдвэрийн хэрэгслийг нийгэмчилсэн нь хоршооллоход үлэмж нааштай үр дүн өгч, ард түмний ахуй байдал хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулсан нь тодорхой. Бүхий л эдийн засагт хоршооллож дууссанаар аж ахуйн нэгдмэл социалист систем буй болсон юм.

Аж ахуйг эрхлэн хөтлөх социалист аргыг аажмаар нэвтрүүлсэн нь шилжилтийн үеийн чухал асуудал байлаа. Улс ардын аж ахуйн бүхий л салбар, үйлдвэрлэлийг удирдахад төлөвлөгөөт аргыг улам бүр өргөн хэрэглэх болжээ. Аж ахуйн тооцоог өргөтгөн, ашиглах анхны алхмууд хийсэн байна.

Социалист интернационализмын зарчимд тулгуурлан ЗХУ болон социалист бусад оронтой нягт хамтын ажиллагаа тогтоосноор шилжилтийн үеийн эдийн засгийн бүх үндсэн зорилтуудыг хэрэгжүүлсэн юм. Хамтын ажиллагааны хамгийн янз бүрийн хэлбэрийг хэрэглэсэн ба тэдгээрийн нэлээд нь анх удаа Зөвлөлт-Монголын харилцааны практикт цаг үеэр шалгагдсан билээ. Үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэхэд санхүүгийн тусламж, техник-эдийн засгийн туслалцаа, хамтын үйлдвэр барьж ашиглах, боловсон хүчин бэлтгэх асуудал онцгой чухал ач холбогдолтой байлаа. Эдийн засгийн биеэ даасан байдлыг хангахад социалист хэлбэрийн гадаад эдийн засгийн улс хоорондын харилцааг бэхжүүлэх нь чухал байв. Үйлдвэрлэлийн харилцааны системийг өөрчлөн байгуулах талаар гэвэл олон хэвшлийг даван туулах арга туршлагаа солилцох, (үндэсний онцлогийг харгалзан) социалист өмчийг бий болгон бэхжүүлэх, нийгмийн үйлдвэрлэлийг зохион байгуулах, эрхлэх бүхий л аргыг нэвтрүүлэх зэргийг ашиглаж байв.

Эдийн засгийн олон салбарт бүтцийг бий болгож, Монгол орныг хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болгон хувиргаж, нийгмийн социалист үйлдвэрлэлийн харилцаа ялан, соёлын байгуулалтыг ихээр өрнүүлсэн энэ бүхэн бол БНМАУ-д 60-аад оны эхээр социализмын үндэс байгуулагдсан, ингэхлээр шилжилтийн үе дууссаныг нотлон харуулж байна.

МАХН-ын программд: «МАХН-ын зөв удирдлага, хөдөлмөрчдийн цуцалтгүй баатарлаг тэмцлийн үрээр Монгол орон феодализмаас социализмд дэвшин орох түүхэн шилжилт хийлээ. Ийнхүү улс орноо капитализмыг алгасан социализм өөд хөгжүүлэх намын жанжин шугам ялав. Бүгд Найрамдах Монгол Ард Улсад социализм үнэн бодит зүйл боллоо»<sup>9</sup> гэж тэмдэглэсэн юм.

Социализмын материал техникийн бааз бүрэн байгуулахын өмнөх үе шатанд улс ардын аж ахуйн бүх салбарт социалист харилцааг бэхжүүлсэн нь БНМАУ дахь шилжилтийн үеийн онцлог юм. Энэ нь улс орны эдийн засгийн хүч чадал өссөн, түүнчлэн үйлдвэрлэх хүчний хоцрогдлыг нэлээд хэмжээгээр нөхөх гэж социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай бүх талаар хамтран ажилласны үрээр бололцоотой болсон байна.

Капитализмын өмнөх харилцаанаас социализмд шилжих үед шинэ нийгмийн материал техникийн бааз байгуулах нь онцгой төвөгтэй, олон талт, урт удаан хугацааны үйл явц бөгөөд энэ үйл явц дуусах үед шилжилтийн үеийн хүрээнээс давж болох юм гэдгийг туршлага гэрчилж байна.

Социализмын материал техникийн зүй зохистой цогцолборыг байгуулж дуусгах нь БНМАУ-ын социалист хөгжлийн өнөө үеийн эдийн засгийн гол асуудал болж байна.

Орос хэлнээс орчуулсан **Л. БЭГЗЖАВ**

### **ХЯТАДЫН ДАЛАЙН ЭРГИЙН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ**

**С. Жаргалсайхан**

Марксизмыг үндэслэгчид «урьд орон нутаг, үндэсний талаар битүү түгжүү байж өөрийнхөө үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр амьдарч байсны оронд, улс үндэстэн тал тал тийшээ хэлхээтэй болж, бие биетэйгээ зүйл зүйлийн холбогдолтой болж ирэв»<sup>1</sup> хэмээн одоогоос 140 гаруй жилийн өмнө бичиж байжээ. Ухаант мэргэдийн энэхүү дүгнэлт улс түмний өнөө цагийн байдалтай яв цав нийцэж, эдүгээ дэлхийн олон улс орон хэзээ хэзээнийхээс илүү «бие биетэйгээ зүйл зүйлийн холбогдолтой болж ирэв. Дэлхийн улс түмэн нягт харилцаа холбоотой болсны учир юун хэмээвээс цөмийн дайны аюулыг зайлуулах асуудал амин чухал болж, шинжлэх ухаан, техникийн хувьсгал гүнзгийрч, үйлдвэрлэх хүч улам бүр олон улсын шинж чанартай болж, байгаль

1. В. И. Ленин. ПСС, т 43, с, 199 (В, И, Ленин зохиолууд 32-р боть, УБ, 1967, 321-р тал орч).
2. В. И. Ленин. ПСС, т, 43, с. 228 (В, И, Ленин зохиолууд 32-р боть, УБ, 1967, 355-р тал орч).
3. 50 лет МНР с. 63
4. Народное хозяйство МНР за, 65 лет (1921—1986) Юбилейный статический сборник, УБ., 1986, с. 100, 101
5. Мөн Тэнд, с. 110, 111
6. Мөн тэнд. с. 127, 128
7. 50 лет МНР с. 196
8. В. И, Ленин. Псс, т, 43, с, 206 (В, И, Ленин зохиолууд, 32-р боть, УБ 1967, 334-р тал)
9. XV съезд Монгольской народно-революционной партии М., 1966, с. 175, 177  
«За № 45»